


VIII ангийн дэвших шалгалтын жишиг даалгавар

1-р хэсэг

- Бие ямар байрлалд хамгийн бага даралт учруулах вэ? / 1 оноо/
A. 1 B. 2 C. 3
- Энергийн нэгжийг сонгоно уу. / 1 оноо/
A. Жоуль B. Ватт C. Ньютон D. Вольт
- Ажил хийгдсэн эсэхийг тогтооно уу. / 1 оноо/
A. Хүнд шүүгээг түлхээд зогсож байна.
B. Утсанд бөмбөг зүүгээд тогтмол хурдаар эргүүлж байна.
C. Ном уншиж байна.
D. Хананд тогтоосон зураг доош унав.
- Гудамжны шороо салхинд хийсэн бужигнахдаа эерэг цэнэгийн илүүдэлтэй болжээ. Барилгын ханад шороо тогтоохгүйн тулд ямар будгаар будах хэрэгтэй вэ? / 1 оноо/
A. Сөрөг цэнэгийн илүүдэлтэй B. Эерэг цэнэгийн илүүдэлтэй
C. Цагаан будаг D. Хар өнгийн будаг
- Дараах физик хэмжигдэхүүнүүдийг хэмжих багажтай зөв харгалзуулна уу. / 1 оноо/
1. Хүчдэл A. Элекроскоп
2. Гүйдлийн хүч B. Ваттметр
3. Цэнэг C. Амперметр
4. Чадал D. Вольтметр
A. 1D 2C 3A 4B B. 1C 2A 3D 4B C. 1A 2B 3C 4D D. 1D 2C 3B 4A
- Ороомгийн соронзон хүчийг хэрхэн ихэсгэх вэ? / 1 оноо/
A. Гүйдлийг нэмэгдүүлнэ B. Гүйдлийг багасгана
C. Ороодсын тоог багасгана D. Аль нь ч биш
- Энергийн эх үүсвэрийг сонго. / 1 оноо/
A. Мод B. Хүн C. Генератор D. Аль нь ч биш
- Нүүрс шатаах үед энергийн ямар хувирал болдог вэ? / 1 оноо/
A. Гэрлийн энерги дулааны энергид B. Химийн энерги дулааны энергид
C. Дотоод энерги механик энергид D. Потенциал энерги кинетик энергид

9. Дараах зурагт цахилгаан энергийн хэдэн хувь нь үр ашиггүй хэлбэрт шилжиж байна вэ? / 1 оноо/

- A. 95%
- B. 5%
- C. 90%
- D. 0



- Хий ба шингэний урсгалаар энерги зөөгдөхийг.....гэнэ./ 1 оноо/
A. Дамжуулал B. Цацрал C. Конвекц D. Бүгд зөв
- Хулан зогсож байна. Түүний жин 400Н ба хоёр гутлын нийт талбай 200см². Хулангийн газарт учруулах даралтыг олно уу. / 2 оноо/
A. 2 Па B. 8 Па C. 20кПа D. 0.5 кПа

12. Шингэнт төхөөрөмжийн бага (шахуургын) бүлүүрийн талбай S_1 , үйлчлэх хүч F_1 том (ажлын) бүлүүрийн талбай S_2 , үйлчлэх хүч F_2 бол дараах хүснэгтийг бөглөнө үү. / 2 оноо/

№	Шахуургын бүлүүр		Ажлын бүлүүр	
	$S_1, (cm^2)$	$F_1 (H)$	$S_2, (cm^2)$	$F_2, (H)$
1	2	50	10	250
2	5		500	10000
3	20	1000	800	


- A. $F_1=0.1kH, F_2= 40kH$
- B. $F_1=0.02kH, F_2= 0.05kH$
- C. $F_1=20kH, F_2= 50kH$
- D. $F_1=0.1H, F_2= 40H$

13. 54 км/ц-ийг м/с нэгж рүү шилжүүлнэ үү. / 2 оноо/


- A. 1.5 м/с
- B. 15 м/с
- C. 194 м/с
- D. 54000 м/с

14. Зурагт машины хурд - хугацааны хамаарлын диаграмм өгөгдөв. Машины масс 3000 кг. Машины хөдөлгөөний II хэсэг дэх кинетик энергийг олно уу. / 2 оноо/

- A. 45кЖ
- B. 2700кЖ
- C. 1350кЖ
- D. 90кЖ




15. Цахилгаан хэлхээний дараах схемүүдийн аль нь зөв бэ? / 2 оноо/



- зураг 1
- зураг 2
- зураг 3
- зураг 4
- A. 1
- B. 2
- C. 3
- D. 4


16. Хөшүүргийн X цэг хүч үйлчлэх цэг болно. Y ба T цэгүүдийг нэрлэнэ үү. / 2 оноо/

- A. Y цэг нь тулах цэг, T цэг нь хүч үйлчлэлийг цэг
- B. Y цэг нь хүчний мөр, T цэг нь хүч үйлчлэлийн цэг
- C. Y цэг нь хүч үйлчлэлийн цэг, T цэг нь тулах цэг
- D. Y цэг нь хүч үйлчлэлийн цэг, T цэг нь хүчний мөр




17. Зурагт машины хурд - хугацааны хамаарлын диаграмм өгөгдөв. Машины масс 3000 кг. Машины I хэсгийн хурдатгалыг олно уу. / 2 оноо/

- A. $30 м/с^2$
- B. $15 м/с^2$
- C. $225 м/с^2$
- D. $2 м/с^2$



18. Цахилгаан хэлхээний зураган дээр вольтметр чийдэнтэй яаж холбогдсон байна вэ? / 2 оноо/



- A. Цуваа
- B. Зэрэгцээ
- C. Цуваа ба зэрэгцээ
- D. Аль нь ч биш

2-р хэсэг


1. Галт тэрэгний хөдөлгөөний нэг хэсгийг хүснэгтэд үзүүлэв.

Хурд, м/с	30	30	30
Хугацаа, с	0	20	40

- A. Галт тэрэгний хурд - хугацааны диаграммыг зурна уу. / 1 оноо/
B. Галт тэрэгний хөдөлгөөнийг үгээр тайлбарлана уу. / 1 оноо/
C. 20с-ийн дараа галт тэрэг ямар хурдтай болсон бэ? / 1 оноо/
D. Галт тэрэг нийт 40с-д ямар зам туулсан бэ? / 1 оноо/

2. Цахилгаан хэлхээний хэсэг өгөгджээ.

а. А чийдэнгээр 3А, В чийдэнгээр 2А гүйдэл гүйж байгаа бол Б ба Г чийдэнгээр гүйх гүйдлийн хүчний хэмжээ хэд байх вэ? / 1 оноо/



б. Чийдэнгүү д хэрхэн холбогдсон бэ? / 1 оноо/

в. Г чийдэнгээр гүйх гүйдлийн хүчийг ямар багаж ашиглан хэмжих вэ? / 1 оноо/

г. Г чийдэнгээр гүйх гүйдлийн хүчийг хэмжих багаж нэмж холбоно уу. / 1 оноо/

д. В чийдэн дээр унах хүчдлийг хэмжих вольтметрийг хэлхээнд нэмж холбоно уу. / 1 оноо/